

**КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУЛГА**  
**ПРЕМИУМ НЭКСУС ХК**

**НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.

№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүл сэн	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, хороодын чиг үүрэг хариуцлагыг нарийвчлан зохицуулсан бөгөөд ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ-ийн 2024 оны 09-р сарын 03-ны өдрийн 35 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.	2	100
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүл сэн	ТУЗ-ийн гишүүдийг томилох, чөлөөлөх асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулж байгаа бөгөөд ТУЗ-ийн 2022 оны 06-р сарын 13-ны өдрийн 19 тоот тогтоолоор Залгамж халааны бодлогыг батлан хэрэгжүүлж байна.	2	100
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандaa байршуулна.	Бүрэн хэрэгжүүл сэн	Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүдийн ажлын туршлага, сургалт хөгжил, Компани дахь хувь эзэмшлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, компанийн засаглалтай холбоотой бусад мэдээллийг тусган тайлагнадаг бөгөөд тайланг МХБ болон Компанийн цахим хуудсанд байршуулдаг.	2	100
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Хэсэгчлэн хэрэгжүүл сэн	Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ болон хороодын бүтэц, бүрэлдэхүүн гишүүдэд тавигдах шаардлага зэргийг тусган хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд гишүүдийн боловсрол, мэргэжил, ур чадвар, туршлагад тавигдсан шаардлага хангагдаж байгаа хэдий ч хүйсийн тэнцвэрт байдал хангагдаагүй байна. Компани нь хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор эмэгтэй гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг идэвхтэй эрэлхийлж байгаа бөгөөд энэ эрмэлзлээ баталгаажуулж гишүүдийн 3/1-ийг нэг хүйсийн гишүүн байлгах зорилтыг 2024 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны журамдаа тусгаад байна.	2	100
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах	Бүрэн хэрэгжүүл сэн	Компани нь ТУЗ-ийн гишүүнийг шинээр томилогох бүрд Компанийн санхүүгийн тайлагнал, бизнесийн	2	100

	ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.		онцлог болон үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, хариуцлага зэрэг мэдээллийг агуулсан танилцах хөтөлбөрт хамруулдаг. 2024 онд Компанийн бизнесийн нэгж бүрийн удирдлагууд ТУЗ-ийн гишүүд, ялангуяа хараат бус гишүүдэд зориулсан нэг өдрийн үйл ажиллагаа танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан.		
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүл сэн	ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог. ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд ТУЗ-ийн НБД-ын эрх үүргийг тусган, мөрдөж ажиллаж байна. 2024 онд ТУЗ-ийн НБД-ын өдөр тутмын ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ Компани дах засаглал, эрсдэлийн менежмент, комплайнсын тогтолцооны нөхцөл байдлын үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулсан.	2	100
ДҮН				12	100

#### ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.

7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хэсэгчлэн хэрэгжүүл сэн	ТУЗ-ийн гуравны нэгээс доoshгүй хувь нь хараат бус гишүүнээр байна. Компани нь хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг идэвхтэй хайж байгаа бөгөөд гишүүдийн олонхыг хараат бус гишүүн байлгахаар зорин ажиллаж байна.	1	50
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцено.	Бүрэн хэрэгжүүл сэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон Аудитын хорооны үйл ажиллагааны журамд заасны дагуу ТУЗ-ийн Аудитын хорооны гишүүдийн 3/2 нь хараат бус гишүүд байгаа бөгөөд хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн ажиллаж байна. Компанийн хараат бус аудитор нь жилийн эцсийн санхүүгийн тайланг Аудитын хороо болон хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн танилцуулдаг бөгөөд Аудитын хорооны хуралд шаардлагатай тохиолдолд Гүйцэтгэх захирлыг оролцуулдаг. 2024 онд Аудитын хороо нь 2 удаагийн үйлдвэр, агуулах болон бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй бусад газруудад эрсдэлийн үнэлгээг биечлэн хийж	2	100

			сайжруулалтын ажлын зөвлөмж гаргасны дагуу Компанийн удирдлагууд холбогдох сайжруулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд холбогдох тайланг сар бүр Аудитын хороонд хүргүүлж байна.		
9	2.3. ТҮЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТҮЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагчхүү хорооны хүсэлтээр оролцно.	Бүрэн хэрэгжүүл сэн	ТҮЗ-ийн үйл ажиллагааны журамд зааснаар ТҮЗ-ийн Цалин урамшууллын хорооны даргаар хараат бус гишүүн ажиллаж байгаа бөгөөд ТҮЗ нь тус хорооны гишүүдээс бүрдүүлэх шийдвэрийг 2024 оны 09-р сарын 01-ний өдөр гаргасан. Тус хороо нь ТҮЗ-өөс 2022 оны 06-р сарын 13-ны өдөр баталсан Цалин урамшууллын бодлогыг баримтлан ажиллаж байгаа бөгөөд ТҮЗ нь тус хорооны үйл ажиллагааны журамд 2024 оны 09-р сарын 03-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан. Мөн тус хорооны хүсэлтээр Компанийн төлөөлөл хорооны хуралд оролцдог. 2024 оны ЦҮ-ын хорооны зөвлөмжийн дагуу цалин урамшуулал тогтоох аргачлал, Компанийн урт, богино хугацааны урамшууллын хөтөлбөрийг ТҮЗ-ийн 2024 оны 42-43 тоот тогтоолоор баталсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна.	2	100
10	2.4. ТҮЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТҮЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэсэгчлэн хэрэгжүүл сэн	Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам болон залгамж халааны бодлогыг 2022 онд батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ТҮЗ-ийн 2024 оны 09-р сарын 01-ний өдрийн 33 тоот тогтоолоор тус хорооны гишүүдээс бүрдүүлж, хорооны даргаар хараат бус гишүүнийг томилсон бөгөөд ТҮЗ-ийн 2024 оны 09-р сарын 03-ны өдрийн 35 тоот тогтоолоор НД хорооны үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулсан.	2	100

11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ нь Байгаль орчин, нийгэм засаглалын хороог 2021 онд байгуулан хорооны үйл ажиллагааны дүрэм журмыг баталсан. БОНЗ-ын хороо нь засаглал, дотоод хяналт, үйл ажиллагааны эрсдэлийн асуудлуудад анхаарал хандуулан ажиллаж байна. ТУЗ-ийн 2024 оны 09-р сарын 03-ны өдрийн 35 тоот тогтоолоор тус хорооны үйл ажиллагааны журмыг шинэчлэн баталсан бөгөөд 2024 онд тус хороо нь Компани болон охин компаниуд дах засаглал, эрсдэлийн удирдлага, комплайнсыг сайжруулах зорилгоор нөхцел байдлын үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгүүлж, богино, урт хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулсан.	2	100
ДҮН				8	80

#### ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана

12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн албан ёсны цахим хуудас болон МХБ-ийн цахим хуудсаар хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон олон нийтэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн хугацаат тайланг нээлттэй тайлагнадгаас гадна тухай бүр мэдээлэх мэдээллийг холбогдох журамд заасан хугацаанд нь МХБ-ийн сайтаар дамжуулан хүргэж байна. Мөн Компанийн санаачилгаар жил бүр хөрөнгө оруулагчдад зориулсан тайлагналын уулзалтыг зохион байгуулж, арга хэмжээний үр дүн болон тайланг МХБ-ийн мэдээ, мэдээлэл сувгаар дамжуулан олон нийтэд хүргэж байна.	2	100
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Энэхүү кодекст заасан баримт бичиг, дүрэм журам, тэдгээрт орсон нэмэлт өөрчлөлтүүд, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээллийг Компанийн цахим хуудсанд нээлттэй байршуулсан.	2	100
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд	Бүрэн хэрэгжүүлсэн	Санхүүгийн болон санхүүгийн бус тайлан мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол холбогдох байгууллагууд болон олон нийтэд хүргэж байгаа бөгөөд Компанийн жилийн тайландаа Компанийн үйл	2	100

	компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.		ажиллагаа, байгаль орчин, нийгэмд нөлөөлж буй нөлөөлөл, эрсдэлийн удирдлага, засаглал зэрэг асуудлуудыг дэлгэрэнгүй тусган нийтэлдэг.		
ДҮН				6	100

#### ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортай хамтран ажиллах тухай дэлгэрэнгүй тусгасан бөгөөд тогтмол мөрдөж ажиллаж байна. ТУЗ-ийн 2024 оны 09-р сарын 03-ны өдрийн 35 тоот тогтоолоор Аудитын хорооны үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд тус журмыг Компанийн цахим хуудсанд байршуулаад байна.	2	100
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн эзлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн хөндлөнгийн аудиторын төлөөлөл хувьцаа эзэмшигчдийн эзлжит хуралд тогтмол оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгч байна.	2	100
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Хэсэгчлэх хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм, дотоод журам, бүтэц бүрэлдэхүүнд тусгасны дагуу үйл ажиллагааны дотоод хяналтыг эрсдэлийн удирдлагын алба, санхүүгийн дотоод хяналтыг санхүүгийн алба хариуцсан ажилладаг бөгөөд ТУЗ-ийн БОНЗ-ийн хороо ерөнхий удирдлагаар хангадаг.	1	50
ДҮН				5	83

#### ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.

18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь Эрсдэлийг бууруулах газартай бөгөөд Компанийн эрсдэлийн төвшин, онцлогт нийцсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын заавар, хөтөлбөрийг баталж, тэдгээрийг мөрдөн ажилладаг. ТУЗ-ийн БОНЗ хороо нь үйл ажиллагааны эрсдэл, Аудитын хороо нь санхүүгийн эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд нь хяналт тавин ажилладаг.	2	100
19	5.2. ТУЗ нь дэргэдээ	Бүрэн	Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг	2	100

	эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь турваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлagnана.	хэрэгжүүл сэн	Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо хариуцан ажилладаг. Тус хороо нь З гишүүнтэй бөгөөд дарга нь хараат бус гишүүн юм. БОНЗ-ын хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж байна. Түүнчлэн 2024 онд Компанийн удирдлагын зүгээс БОНЗ хорооны дэргэдэх эрсдэлийн дэд хороог байгуулах ажлын санал санаачилгыг гарган ажилласан бөгөөд тус асуудлыг 2025 оны 2-р улиралд ТУЗ-д танилцуулан шийдвэрлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.		
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Бүрэн хэрэгжүүл сэн	ТҮЗ-ийн Байгаль орчин, нийгэм засаглалын хороо нь БОНЗ-ын талаарх алсын харааг боловсруулах, заавар зөвлөмжийг өгөх, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлага, компанийн засаглалын талаарх компанийн бодлогыг тодорхойлох гэх мэт чиг үүргийн дагуу ажилладаг. Мөн Компани нь өөрийн БОНЗ-ыг жил бүр хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэн зөвлөмж гаргуулдаг бөгөөд үүний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг жилийн тайлан даа тусган олон нийтэд нээлттэй мэдээлж байна.	2	100
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТҮЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүл сэн	ТҮЗ-ийн 2022 оны 09-р сарын 30-ны өдрийн 32 тоот тогтоолоор Комплайнсын хяналтын зааврыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ТҮЗ нь Компанийн эрсдэлийн төвшин, онцлогт нийцсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг. Компани нь 2024 онд өөрийн комплайнсын тогтолцоог хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэн зөвлөмж зөвлөгөө авсан бөгөөд зөвлөмжийн дагуу сайжруулалтын ажлыг цаашид зохион байгуулахаар төлөвлөөд байна.	2	100
ДҮН				8	100

### ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна.

22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрмийн дагуу ТУЗ нь ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээг тогтоодог бөгөөд ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын мэдээллийг Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тайлагнадаг.	2	100
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн Цалин, урамшууллын хороо нь компанийн цалин урамшууллын зарчим, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхойлж, хяналт тавин ажилладаг. ТУЗ нь 2024 онд ЦҮ-ын хорооны зөвлөмжийн дагуу Компани болон охин компаниудын гүйцэтгэх удирдлагуудын цалин урамшууллыг бodoх аргачлал, гүйцэтгэх удирдлагын урт, богино хугацааны урамшууллын хөтөлбөрийн журмыг батлан, хэрэгжүүлж эхлээд байгаа бөгөөд тус аргачлал, журамд гүйцэтгэлийг хэрхэн үнэлэх талаар нарийвчлан тодорхойлсон.	2	100
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Жилийн үйл ажиллагааны тайланд ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад олгосон нийт цалин урамшуулал, гүйцэтгэлийн шалгуурыг тусган боловсруулж байна.	2	100
<b>ДҮН</b>				<b>6</b>	<b>100</b>

### ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ.

25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй, хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дүрэм болон Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээнд тусгайлан заасан байдаг. Компанид мөрдлөг болгон ашигладаг төрийн байгууллага, хуулийн этгээдтэй харилцах журам, худалдан авалтын үйл ажиллагааны журам болон ёс зүйн дүрмийг баримтлан ажилладаг. Компани нь хөрөнгө оруулагч, олон нийт, оролцогч талуудтай хамтран ажиллах ажилтнуудыг тусгайлан томилсон байдаг.	2	100
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны тайланд стратегийн ач холбогдол бүхий талууд болон бусад холбогдох талуудтай хамтран ажилласан талаар мэдээллийг нээлттэй танилцуулдаг.	2	100

	хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.				
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудас болон сошиал сайтуудаар компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол мэдээлэн ажилладаг.	2	100
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дотоод журам, Шүгэл үлээх журам, Ёс зүйн дүрэмд санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, Хөдөлмөрийн дотоод журам болон бусад хүний неецийн багц журмуудад ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх зэрэг олон талын асуудлыг тусгасан байдаг бөгөөд журмын хэрэгжилтийг хангулж, хяналт тавих ажлыг БОНЗ хороо, Ёс зүйн хороо, ХН алба, эрсдэлийн удирдлагын алба зэрэг газрууд хариуцан ажиллаж байна.	2	100
ДҮН				8	100

#### НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ

ТУЗ-ийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно.

29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн философиийг тодорхойлон цахим хуудсаар дамжуулж нийтэд нээлттэй байршуулсан. ТУЗ-ийн 2022 оны 06-р сарын 13-ны өдрийн 19 тоот тогтоолоор Ёс зүйн дүрмийг батлан тогтмол хэрэгжүүлж ажиллаж байна. Мөн Компани нь өөрийн Ёс зүйн дүрмийг шинэчих ажлыг 2024 оны 4-р улиралд эхлүүлээд байгаа бөгөөд шинэчилсэн дүрмийг 2025 оны 2-р хагас жилд ТУЗ-вөр хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна.	2	100
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх шүгэл үлзээгчийн тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн ажилтан ёс зүйн дүрэм зөрчсөн, зөрчиж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдлийг Компанийн эрсдэлийн удирдлага, ХН-ийн нэгжид мэдэгдэх шүгэл үлзээгчийн тогтолцоотой ажилладаг ба санал, хүсэлт, гомдлын мөн чанараас шалтгаалан асуудлыг холбогдох нэгж, удирдлага, Ёс зүйн хороо шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд ТУЗ шийдвэрлэдэг.	2	100
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны журамд тодорхой хэлбэрээр буюу Ёс зүйн дүрэмд зааснаар зохицуулдаг.	2	100

	үйл ажиллагааг дэмжих, (дэмжихгүй байх) хандив өргөх (өргөхгүй байх) талаар зохицуулна.				
ДҮН				6	100

#### ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.

32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүл сэн	МХБ-ийн цахим хуудсаар болон компанийн цахим хуудсаар дамжуулан санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээлэл, бүтэц зохион байгуулал, сонирхлын зөрчилтэй хэлцэл, ТУЗ-ийн гишүүдийн Компани дах хувь эзэмшил, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид гэх зэрэг мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд нээлттэйгээр мэдээлж байна.	2	100
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжүүл сэн	Компани нь өөрийн цахим хуудсанд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд зориулсан тусгай цэсийг хөгжүүлэн нийтэлсэн бөгөөд мэдээлэлд өөрчлөлт орох бүрд нь шинэчлэн ажиллаж байна. Мөн Компанийн хөрөнгө оруулагч хариуцсан ажилтан нь улирал тутам хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх болон бусад холбогдох ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажиллаж байна.	2	100
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа Эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Бүрэн хэрэгжүүл сэн	Хувьцаа эзэмшигчийг хуралд оролцох, санал өгөх боломжийг биеэр болон онлайнаар, зайнаас оролцох системийн тусламжтайгаар бүрэн хангадаг. Энэ асуудлыг холбогдох журмын дагуу мөрдөж ажилладаг.	2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Бүрэн хэрэгжүүл сэн	Компанийн хувьцаа эзэмшигч эрхээ хэрэгжүүлэх, санал өгөх эрх нээлттэй, ил тод байдаг ба 2024 онд хувьцаа эзэмшигчдээс аливаа хүсэлт, санал хүлээн аваагүй байна.	2	100
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зерчигдэхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэсэгчлэн хэрэгжүүл сэн	Компанийн дүрэмд зааснаар ТУЗ-ийн гишүүн нь аливаа сонирхлын зөрчил байгаа эсвэл сонирхлын зөрчил үүсэж болзошгүй талаар ТУЗ-ийн даргад тайлагнана. ТУЗ-ийн 2024 оны 06-р сарын 10-ны өдрийн 24 тоот тогтооолоор Сонирхлын зөрчлийг мэдүүлэх, шийдвэрлэх журамд нэмэлт өөрчлөл оруулан баталсан.	2	100

			Мөн 2024 онд ТУЗ болон удирдлагатай холбоотой сонирхлын зэрчил гаралагүй ба тэдгээртэй холбоотой сонирхлын зэрчилтэй хэлцэл хийгдээгүй байна.		
ДҮН				10	100
НЭГДСЭН ДҮН				70	97.0

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

Т.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТАЙЛАНГ ХЯНАЖ БАТАЛСАН:

А.Ганхуяг, Гүйцэтгэх захирал

2025.04.17



О.Ганхуяг



2024 оны Компанийн засаглалтын тайлан

↗ Премиум Нэксус ХК  
**ЗАСАГЛАЛ**

## Премиум Нэксус ХК -ийн засаглалын бүтэц нь...


- ✓ Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн, үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, нөөц, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг.
- ✓ Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон олон улсад танигdsan шилдэг туршлага, зарчмуудыг баримталж, үйл ажиллагаандaa нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд сайн засаглал нь бизнесийн стратегийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах, бизнесийн ёс зүй, ил тод, шударга байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг.



## Хувьцаа эзэмшигчид

Компани нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох албан ёсны зөвшөөрлөө **2021 оны 10-р сарын 13-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо ("СЗХ")-ноос авч 2021 оны 11-р сарын 03-ны өдөр Монголын хөрөнгийн бирж ХК ("МХБ")-ийн III дугаар ангиллаар нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч арилжаагаа амжилттай дуусгаж, 2021 оны 11-р сарын 12-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаагаа нээнээр нээлттэй хувьцаат компани болсон бөгөөд МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 05-р сарын 05-ны өдрийн А/42 тоот тушаалаар Компанийн үнэт цаасыг ангилал ахиулан II дугаар ангилалд бүртгэсэн.**

2024 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар МХБ, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгэгдсэн Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны тоо **1,114,252,034**, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо **9,974** байсан. Компанийн нөлөө бүхий болон олон нийтийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл болон Компанийн бүтцийг дор харуулав.

 Хувьцаа эзэмшигчдийн бүтэц (2024 оны 12-р сарын 31-ний байдлаар)

 Нийт гаргасан энгийн хувьцааны өөрчлөлт

Нийт хувьцааны тоо	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо
2022.12.31	
817,768,643	10,108
2023.12.31	
817,768,643	9,615
2024.12.31	
1,114,252,034	9,974

 **Компанийн бүтэц**

Премиум Корпорэйшн 2015 онд өөрийн 100 хувийн хөрөнгө оруулалтаар Сэнтрал Экспресс нэrtэй Монголын анхны конвениенс дэлгүүрийг нээж байв. 2017 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг байгуулж, 2018 оны 8-р сард дэлхийн конвениенс дэлгүүрийн жишиг стандартын төлөөлөл, БНСУ-ын Би Жи Эф Ритэйл компанийтай хамтран ажиллаж СУ брэндийн франчайз эрхийг хүлээн авч, Компанийн нийт хувьцааны 10 хувийг эзэмшүүлэх хөрөнгө оруулалт татаж Монголын зах зээлд нэвтрүүлсэн. БиЖиЭф Ритэйл нь БНСУ-д 18,000 гаруй СУ салбар дэлгүүртэй, жижиглэн худалдааны зах зээлийн тэргүүлэгч компани юм. 2021 онд Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК нь Монголын Хөрөнгийн Бирж дээр IPO амжилттай хийж хувьцаат компани болсон ба улмаар 2023 оны эцэст хувьцаа эзэмшигчдийн хурлаар хөгжлийн дараагийн шатандaa гарах шийдвэрээ баталж, шинээр хувьцаа гаргах замаар босоо интеграцийн хөрөнгө оруулалт болох Чингис Шар Айраг ХХК, Чингис Шар Айраг Клуб ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК болон Стора Централ ХХК нарыг нэгтгэсэн бөгөөд Компанийн нэрээ Премиум Нэксус ХК болгон өөрчилсөн. Мөн 2024 онд Компани нь өөрийн 100 хувийн хөрөнгө оруулалттай хүнсний бөөний болон жижиглэн худалдаа, хүнсний агуулахын үйл ажиллагаа эрхлэх үүрэг бүхий Премиум Нэксус Логистикс ХХК, хүнсний агуулахын болон тээврийн үйл ажиллагаа эрхлэх үүрэг бүхий Премиум Коммерс ХХК компаниудыг шинээр үүсгэн байгуулсан.



2015

- Монголын хамгийн анхны конвениенс дэлгүүр Сэнтрал Экспресс сүлжээг 3 салбар дэлгүүртэйгээр нээв.

2017

- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг үүсгэн байгуулав.

2018

- СУ брэндийн мастер франчайз эрх эзэмшигч БНСУ-ийн Би Жи Эф Ритайл компанийтай гэрээ байгуулж СУ брэндийн франчайз эрх хулээн авав.
- Монголын анхны “Анхны ая тухтай” дэлгүүрийн MNS гэрчилгээг авав.

2019

- СУ брэнд 1 жилийн дотор 50 салбар дэлгүүртэй болов.
- СУ үнэнч хэрэглэгчийн хөтөлбөрийг эхлүүлж СУ апликацийшныг нэвтрүүлэв.

2020

- Энгийн температурын горимтой 4200МКВ талбайтай түгээлтийн төв ашиглалтад оров.
- Монголын хамгийн анхны 100 салбар дэлгүүртэй сүлжээ болов.
- Олон улсын GMP, HACCP стандартыг хангасан Монголын хамгийн анхны нийтийн хоолны үйлдвэр ашиглалтад оров.



2021

- Хүйтэн хэлхээний түгээлтийн төвийг ашиглалтад оруулав.
- CU брэндхувьцаагаа гаргав.

2022

- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь Сиркл Чейн ХХК-ийн Circle K сүлжээ дэлгүүрийн 12 салбарыг худалдан авах хэлцэлд гарын үсэг зурж баталгаажуулж кавсан.
- CU сүлжээ дэлгүүрийн нэг ёдрийн борлуулалт 1 тэрбум төгрөгт хүрэв.
- Монголын хамгийн анхны 200 салбар дэлгүүртэй сүлжээ болов.

2023

- БНСУ-ын neuxay бүхий Мэдээллийн технологийн цогц систем хөгжүүлж, сүлжээний хэмжээнд нэвтрүүллээ.
- CU брэндийн орон нутаг дахь анхны салбар дэлгүүр нээгдэв.
- Топ 100 аж ахуйн Top 100 аж ахуйн нэгжээр 2 дахь удаагаа шалгарч, 11-р байранд эрэмбэлэгдлээ.
- Монголын хамгийн анхны 300 салбар дэлгүүртэй сүлжээ болов.
- CU брэндийн франчайз хөтөлбөрийг голбан ёсоор эхлүүлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд хоолны үйлдвэртайчлал зохион байгуулав.

2024

- Уйлажиллагааны ашигт ажиллагаанд хүрэв.
- Топ 100 аж ахуйн нэгжээр 3 дахь удаагаа шалгарч, 8-р байранд эрэмбэлэгдлээ.
- Монголын хамгийн анхны 400 салбар дэлгүүртэй сүлжээ болов.



## Компанийн бүтэц



Премиум Нэксус ХК

**83.22%**  
Чингис Шар Айраг  
ХХК**100%**  
Чингис Шар Айраг  
Клуб ХХК**83.22%**  
Сентрал Коммерс  
ХХКЗахирал  
Ч. Очирихуяг**100%**  
Премиум Коммерс  
ХХКЗахирал  
Ц. Бархас**83.22%**  
Сентрал Фүүдс  
ХХКЗахирал  
Д. Жүгдэрнамжил**65.90%**  
Стора Централ  
ХХКЗахирал  
О. Энхжин**90.91%**  
Сэнтрал Кофе  
Роустинг ХХК**100%**  
Премиум Нэксус  
Ложистикс ХХКЗахирал  
С. ДашдоржЗахирал  
Ч.Очирихуяг



### 3. Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн хувьцаа  
эзэмшигчдийн эрхээ  
хэрэгжүүлэх гол хэлбэр нь  
хувьцаа эзэмшигчдийн  
хурал бөгөөд хувьцаа  
эзэмшигчдийн хурлаар  
Компанийн тухай хууль  
болон Компанийн  
Дүрмийн холбогдох  
заалтуудын дагуу хувьцаа  
эзэмшигчдийн хурлын  
бүрэн эрхэд хамаарах  
асуудлуудыг хэлэлцүүлэн  
шийдвэрлүүлдэг.



Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд, Компанийн  
Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-өөс баталсан Хувьцаа  
эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журам болон Санхүүгийн  
зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн  
хурлын зар хүргэх журмын дагуу **Компанийн Хувьцаа**  
**эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04-р сарын 25-ны**  
**өдрийн 11:00 цагт** биечлэн болон цахим хэлбэрээр хуралдуулсан  
бөгөөд тус хуралд нийт саналын эрхтэй **хувьцаа эзэмшигчдийн**  
**89.04 хувь** нь оролцож Компанийн 2023 оны жилийн үйл  
ажиллагааны тайлан болон 2023 оны санхүүгийн жилийн цэвэр  
ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн  
шийдвэр, түүний шалтгаантай танилцаж, 2023 оны үйл  
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн  
гаргасан дүгнэлтийг баталсан.



## 4. Хувьцаа эзэмшигчдийн эрх

Компани нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хангах үүднээс тайлант хугацаанд хуралдуулсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийг хурлаар хэлэлцэх асуудлуутай холбоотой танилцуулга материалтай танилцах, <https://hural.cumongol.mn> веб хаягаар хуралд бүртгүүлэх, урьдчилан санал өгөх боломжоор хангаж ажилласан. Мөн энэ хурад ТУЗ-ийн бүх гишүүд, Гүйцэтгэх удирдлагыг оролцуулж хурлаар хэлэлцсэн асуудлуутай холбоотой хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт, тодруулга өгсөн бөгөөд ээлжит хуралд Компанийн хараат бус аудитор Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн төлөөлөгчид оролцож Компанийн 2023 оны санхүүгийн жилийнтайнлангийн хараат бус аудиторын тайлан, дүгнэлт, дүгнэлтийн үндэс, хараат бус байдал, аудитын арга барил, аудитын гол асуудлууд болон бусад холбогдох асуудлуудыг танилцуулсан байна.



## 5. Хувьцааны гүйцэтгэл

Премиум Нэксус ХК-ийн  
зах зээлийн үнэлгээ

**232,332,691,609 ₮**

МХБ-д бүртгэлтэй  
компаниудын зах зээлийн  
нийт үнэлгээ

**12,993,223,761,156 ₮**

Эзлэх хувь

**1.79 %**



Компанийн  
зах зээлийн  
үнэлгээ

**232** тэрбум төгрөг байсан ба

МХБ-ийн зах  
зээлийн  
үнэлгээгээр

**11**-р байранд эрэмбэлэгдэж,

нийт зах  
зээлийн

**1.79**

хувийг бүрдүүлж байна.

Компанийн

**MSE:CUMN**

хувьцаа нь 2024 онд МХБ-  
ийн хувьцааны арилжааны  
үнийн дүнгийн эрэмбээр

**9**

-д, арилжаалагдсан тоо ширхгийн эрэмбээр

**4**

-т тус тус  
жагссан.

2024 оны байдлаар МХБ-ийн  
хоёрдогч зах зээлийн хувьцааны  
арилжааны үнийн дүнгийн

**3,1%**

-г эзэлж  
байсан  
байна.



## 5. Хувьцааны гүйцэтгэл

МХБ-ийн хоёрдогч зах зээлийн  
хувьцааны арилжааны дүн


**317,522,241,254 ₮**

Хувьцааны арилжаа үнийн  
дүнгээр

**9,835,251,338 ₮**

Эзлэх хувь

**3.10 %**



## 6. Ногдол ашиг

Компанийн ТҮЗ-өөс Ногдол ашгийн журмыг баталсан бөгөөд тус журам нь  
Компанийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг болох бөгөөд хувьцаа  
эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, хуваарилах  
нөхцөлийг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах,  
хуваарилах, мэдээлэх, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулдаг.  
ТҮЗ-өөс 2025 оны 02-р сарын 10-ны өдрийн 2 тоот тогтоолоор 2024 оны  
санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй  
байхаар шийдвэрлэсэн.



## 7. Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компани нь тайлант хугацаанд 1 сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн бөгөөд энэ нь өөрийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор нэгдмэл сонирхолтой этгээд болох **Премиум Конкрит ХХК-иас 17.1 хувийн хүйтэй 8-н тэрбум төгрөгийн богино хугацаат зээл авсан хэлцэл** байв.



## 8. Мэдээллийн ил тод байдал, тайлагнал

Компани нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, бусад оролцогч талуудад мэдээллийг олон эх сурвалжаар, нэгэн зэрэг, ил тод хүргэх нь хувьцаа эзэмшигчдийн итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдад Компанийн үйл ажиллагаа болон бизнесийн стратегийн талаар үнэн зөв, бодит ойлголтыг өгөхөд чухал үүрэгтэй хэмээн үздэг. Компани нь өөрийн цахим хуудас, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу хэвлэн нийтлэх, болон тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр мэдээллийг цаг тухайд нь хүргэж байна.

## 9. Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ нь хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлсэн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлж, гүйцэтгэх удирдлагыг Компанийн зорилго, зорилт, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдан чиглүүлж, хяналт тавин ажилладаг.



### ⌚ Бүрэн эрхийн хугацаа

- ТУЗ-ийн дарга болон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа:  
**3 жил**

### 📅 Томилгоо ба огцруулах журам

- Томилох, бүрэн эрх тогтоох, хугацаанаас өмнө огцруулах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэнэ.
- Санал хураалт: Кумулятив аргаар явагдана.
- Улируулан сонгох боломжтой.

ТУЗ нь тогтвортой хөгжлийн зорилт болон Хүний эрхийн зарчмуудыг баримтлал болгон шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэй гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхийг зорин ажилладаг.

2024	ТУЗ-ийн бүрэлдэхүүний	22.2%	
Нийт ажиллагсдын дундаас дээш удирдлагын	48%		
Хувь, ханган нийлүүлэгчдийн нийт ажиллагсдын дундаас дээш удирдлагын	76%		

### Нэр дэвшүүлэхдээ:

- Нэр дэвшигчийн нэр дэвшүүлсэн үндэслэл
- ТУЗ-ийн хуралд оролцсон ирц
- Ажлын гүйцэтгэл-ийг харгалзан үзнэ.

### 🕒 Гишүүн чөлөөлөгдөх буюу үүрэг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд

- Нөхөн сонгууль хүртэл:
  - ТУЗ түр гишүүн томилж болно.
  - Тухайн этгээд нь хууль ёсны эрх бүхий нөхөн гишүүнээр ажиллана.



## 9. Төлөөлөн удирдах зөвлөл



Гари Стивен Биондо  
ТУЗ-ийн дарга  
Премиум Нэксус ХК



Адилбишийн Ганхуяг  
ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал  
Премиум Нэксус ХК



Адилбишийн Ганболд  
ТУЗ-ийн гишүүн  
Премиум Нэксус ХК

**Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo)** нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн дарга (хараат бус) бөгөөд Улаанбаатар дах Олон Улсын Дунд Сургуулийн ТУЗ-ийн дарга, Монгол дах АНУ-ын худалдааны танхим (АмЧам Монгол)-ын ТУЗ-ийн дарга, Эдельвайс Арт зочид буудлын гүйцэтгэх захирал юм. Тэрээр 35 гаруй жил зочид буудлын менежментийн салбарт, тэр дундаа ажилчдын сургалтын хөтөлбөр, Хөдөлмерийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, чанар, дотоод хяналтын удирдлага, галын аюул, осол үүсэх эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан туршлагатай. Гари Биондо нь Азийн өөр өөр соёл иргэншилтэй олон улс орнуудад өндөр зэрэглэлийн Шангри-Ла олон улсын зочид буудал, резортод 28 жил ерөнхий менежер, гүйцэтгэх удирдлагаар ажилласан бөгөөд АНУ-ын Колорадо мужийн Колорадо Коллежийг сонгодог уран зохиол, гүн ухааны чиглэлзэр бакалаврын зэрэгтэй төгссөн.

**Адилбишийн Ганхуяг** нь Премиум Корпорэйшний үүсгэн байгуулагч, Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал бөгөөд сүүлийн 23 гаруй жил Монголын нэр нөлөө бүхий томоохон компаниуд болох М-Си-Эс Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Кока-Кола ХХК болон Юнител ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Монголиан Майнинг Корпорацийн (HKEX: 975)-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгч, Улаанбаатар Хотын Худалдааны Танхимиын Ерөнхийлөгчөөр ажиллаж ирсэн туршлагатай. Тэрээр эдгэрр компаниудын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, таниулахад үнэтэй хувь нэмэр оруулж, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц, барилга, худалдааны салбарт томоохон хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах ажлыг амжилттай удирдан зохион байгуулсан. А.Ганхуяг нь Монгол Улсын Их Сургуулийг санхүү, эдийн засгийн бакалавр, Квантик Бизнес, Технологийн Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

**Адилбишийн Ганболд** нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Корпорэйшний үүсгэн байгуулагч, Премиум Иннова ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн бөгөөд түүний зэрэглээ, хараат компаниудын үйл ажиллагааг удирдан, стратегийн чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын авто зам барилга, хотын дэд бутцийн компани болох Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирал, тансаг зэрэглэлийн тавилга үйлдвэрлэгч Ганброс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захираараар ажиллаж байсан. Түүний барилгын салбарын хөгжилд оруулж буй хувь нэмрийг тэр засгаас өндөрөөр үнэлж Алтан гадас одонгоор шагнасан юм. Тэрээр Оросын Холбооны Улсын Харьков хотын Барилгын дээд сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль ("ШУТИС")-ийг цахилгаан тээвэр, системийн инженер мэргэжлээр суралцсан, бакалаврын зэрэгтэй.



## 9. Төлөөлөн удирдах зөвлөл



Ганшушийн Бат-Эрдэнэ  
ТУЗ-ийн гишүүн  
Премиум Нэксус ХК



Чойжин-Осорын Мөнхчимэг  
ТУЗ-ийн гишүүн  
Премиум Нэксус ХК



Ганболдын Чинзориг  
ТУЗ-ийн гишүүн,  
Гүйцэтгэх захирлын орлогч  
Премиум Нэксус ХК

Ганшушийн Бат-Эрдэнэ нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүүхариуцсан захирал, Премиум Иннова ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүүхариуцсан захирлаа ажилладаг. Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Коика Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлж байв. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, барилгын салбартажиллаж, Монголиан Майнинг Корпораци (HKEX: 975) болон Премиум Групп ХХК-ийн санхүүгийн ўйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүүхариуцсан Дэд ерөнхий лөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.Бат-Эрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

Чойжин-Осорын Мөнхчимэг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Корпорэйшний Хүний нөөц хариуцсан захирал бөгөөд олон улсын томоохон төслийд тооцогдох Оюу Толгой төсөл дэх Бетон зуурмагийн үйлдвэр, Салхин сэнсний төсөл, Шинэ нисээ онгоцны барилгын төсөл, Шангри-Ла зочид буудал, худалдааны төв төслийдэд мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бурдуулж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүдийг бэлтгэн, төслийдгүй амжилттай хүлээлгэн өгөхөд үнэтэй хувь нэмэр оруулсан. Мөн тэрээр 2004-2012 онуудад үндэсний томоохон групп компани болох М-Си-Эс Групп болон Энержи Ресурс ХХК-ийн Ухаа худаг салбарт Захиргаа, хүний нөөцийн алба хариуцсан менежерээр ажиллаж байсан туршлагатай. Ч.Мөнхчимэг нь Удирдлагын Академийг төрийн захиргааны удирдлагын бакалаврын зэрэгтэй төгссөн.

Ганболдын Чинзориг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирлын орлогч юм. Тэрээр программ хангамж, бизнес процесс, бизнес интелижанс, мэдээллийн технологийн мастер төлөвлөлт, инженерчлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газар ("МТШХГ")-ын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлгат Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба ерсэлдэх чадварын төслийн мэдээллийн технологийн зөвлөх, Азийн Хөгжлийн Банкны Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөл, Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн систем ба санхүүгийн дэд бутцийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр МТШХГ-д ажиллаж байхдаа Цахим засаглал хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, Монгол Улсын Харилцаа холбоо, интернет, шуудан, хэвлэл мэдэлэл, хиймэл дагуулын холбооны талаар баримтлах төрийн бодлого болон Мобайл сүлжээний 4G үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зохицуулалтын бодлогыг боловсруулсан. Г.Чинзориг нь ШУТИС-ийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Луисвиллийн Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



## 9. Төлөөлөн удирдах зөвлөл



**Болдбаатарын Бат-Эрдэнэ**  
ТУЗ-ийн гишүүн  
Премиум Нэксус ХК



**Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Премиум Нэксус ХК



**Ванчигийн Ганзориг**  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
Премиум Нэксус ХК

**Болдбаатарын Бат-Эрдэнэ** нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Польшийн Хөгжлийн Сангийн Хөрөнгө Оруулалт Худалдааны Агентлагийн Монгол дахь суурин төлөөлөгч, Хорайзон Партийн ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, худалдааны чиглэлээр 16 гаруй жил ажилласан түршлэгтай. Тэрээр Польш, АНУ, Швейцар үлсад сурч, Монголын анхны гадаадын (Японы) хөрөнгө оруулалтын банканд зах зээлийн шинжээчээр, Олон Улсын Санхүүгийн Корпорац болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалттай Монголын анхны хаалттай хөрөнгө оруулалтын санд (50 сая ам. долларын) зах зээл, бизнесийн шинжээчээр, Польш-Монголын хамтарсан худалдааны компанийн Гүйцэтгэх захирагар ажиллах байсан ба Азийн Хөгжлийн Банкны Монгол үлсад "Private Equity" болон "Venture Capital" хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх компанийн ажилласан хөрөнгө оруулалт, стратеги, менежментийн зөвлөх үйлчилгээний компанийн үүсгэн байгуулагч юм. Б.Бат-Эрдэнэ нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн

**Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг** нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хөдөө аж ахуй, зүүл мэндийн чиглэлээр дагнан судалгаа, үнэлгээ хийдэг Когнос Интернэйшнал ХХК-ийн Захирал, үүсгэн байгуулагч юм. Тэрээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хүн амын сан, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, ЮНЕСКО, Европын холбоо гэх мэт олон улсын байгууллагууд болон төр, хувийн хэвшлийн бодлого, хөтөлбөр, стратеги мөн Тогтвортой хөгжлийн зорилгын судалгаа, үнэлгээ дээр сүүлийн 14 жил ажиллаж байна. Эрдэнэчимэг нь Монголын үнэлгээний холбооны үүсгэн байгуулагч, ТУЗ-ын дарга бөгөөд Америкийн үнэлгээний холбоо, Монголын үнэлгээний холбооны Нийгмийн нөхөнлийн хэмжилт ба Байгаль орчин, нийгэм, засаглалын салбар булгийн гишүүн, Үнэлгээний хамтын ажиллагаланы төлөөх олон улсын байгууллага (IOCE), Ази номхон далайн үнэлгээний холбоо (APEA)-ны Үнэлгээг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх аклын хэсгийн гишүүнээр тус тус ажилладаг. Эрдэнэчимэг нь МУИС-д хүн амзүйн докторант ба Английн Лондоны Эдийн Засгийн Сургуульд нийгмийн судалгыны аргазын магистр, Тайландын Махидолын Их Сургуульд хүн ам, нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгааны магистр зэрэг тус тус хамгаалсан.

**Ванчигийн Ганзориг** нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд стратеги ба коммуникацийн чиглэлээр мэргэшсэн Бат Солюшн Партерс ХХК-ийн Удирдах зөвлөлийн дарга, "CEO" клубийн ерөнхийлөгч, Монголын Дауны Холбоо, Менторшилийн залуу мэргэжилтнүүдийн хөтөлбөрийн тэргүүн. Монголын Тусгай Олимпийн Хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, "Global Teacher Prize"-ийн академийн гишүүн, Синдикат ярилцлагын нэвтрүүлгийн модератор, тэргүүлэх мэдээллийн сайтуудын нийтлэлчээр ажилладаг. Тэрээр Худалдаа Хөгжлийн Банк, Хасбанк, МОСДАК, Шүнчлэй Группийн удирдлагын багт ажиллаж байсан түршлэгатай бөгөөд Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2014 оны дэлхийн залуу манлайлагчаар шалгарсан. В.Ганзориг нь Японы Олон Улсын Их Сургуулийг цахим бизнесийн удирдлагын магистр, Австралийн Нотре Dame Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд АНУ (Virginia, Yale), Англи (Oxford), Өмнөд Африк (WITS, Cape Town), Сингапур (NUS) улсуудад удирдлага, манлайлал, бодлогын инновац, гео улс төр, өөрчлөлтийн менежмент чиглэлээр мэргэжлийн сургалтуудад хамрагдсан Монголын Улсын мэргэшсэн зөвлөх юм.



# ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН СУРГАЛТ, ХӨГЖИЛ

## Шинээр томилогдсон гишүүдийн танилцах хөтөлбөр

Компанид шинээр томилогдож буй ТУЗ-ийн гишүүдийг дараах агуулгатай танилцах сургалтад тогтмол хамруулдаг. Үүнд:

- Компанийн санхүүгийн тайлагнал
- Бизнесийн онцлог болон үйл ажиллагаа
- ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, хариуцлага

## Олон улсын цахим сургалт

- Платформ: Harvard Business Publishing
- Сургалтын чиглэл:
  - Харвардын менежмент
  - Менторын ур чадварууд
- Хамрагдагчид: ТУЗ-ийн гишүүд болон удирдах албан тушаалтнууд
- Төлөвлөгөө: Сургалт 2025 онд үргэлжилнэ

## 2024 оны сургалтын үйл ажиллагаа

- Огноо: **2024 оны 06-р сарын 17**
- Зохион байгуулагчид:
- Компанийн засаглалын үндэсний зөвлөл
- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

## Сургалтын сэдвүүд:

- Компанийн засаглалын сүүлийн үеийн чиг хандлага
  - ТУЗ-ийн үйл ажиллагааг үр ашигтай болгох арга замууд
  - Компанийн засаглалын маргаан шийдвэрлэх аргачлал
  - Комплайнсын бодлого ба эрсдэлийн менежмент
- Үр дүн: ТУЗ-ийн гишүүд гэрчилгээтэй төгссөн



## ТУЗ-ИЙН ЦАЛИН УРАМШУУЛАЛ

2024 оны санхүүгийн жилд ТУЗ-ийн хараат бус гишүүдэд сарын 3 сая төгрөгийн цалин урамшуулал олгосон байна. ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын Компанид эзэмшиж буй хувьцааны тооны мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

ТУЗ-ийн гишүүний нэр	Эзэмшиж буй хувьцааны тоо		Нийт хувьцаанд эзлэх хувь	
	Шууд	Шууд бус	Шууд	Шууд бус
Гари Биондо (дарга, хараат бус)	-	-	-	-
А.Ганхуяг	300,848,138	72,298,639	27.00%	6.49%
А.Ганболд	207,204,006	55,046,424	18.60%	4.94%
Г.Бат-Эрдэнэ	22,572,047	6,063,140	2.03%	0.54%
Ч.Мөнхчимэг	-	-	-	-
Г.Чинзориг	6,842,227	-	0.01%	-
Б.Бат-Эрдэнэ	80,000	-	0.61%	-
Ө.Эрдэнэчимэг	-	-	-	-
В.Ганзориг	2,709	-	0.00%	-

 ТУЗ-ийн хороод**1. Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо (БОНЗ)**

- ESG бодлого тодорхойлох, хэрэгжилт хянах
- Хууль, ёс зүйн баримт бичиг боловсруулах, хэрэгжилтийг хянах
- ТУЗ-ийн гишүүдийн үр нөлөө, оролцоог үнэлэх
- Сургалт, мэргэшлийг дэмжих

**2. Нэр дэвшүүлэх хороо**

- ТУЗ-д шаардагдах мэдлэг, ур чадвартай нэр дэвшигчийг тодорхойлох
- ТУЗ-д санал, зөвлөмж гаргах

**3. Цалин урамшууллын хороо**

- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын бодлого боловсруулж хянах
- Шударга, тогтвортой урамшууллын тогтолцоо бүрдүүлэх

**4. Аудитын хороо**

- Дотоод хяналтын системийг бүрдүүлэх
- Санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавих
- Ёс зүйн хэм хэмжээг бататгах

## Хорооны бүтэц (Хураангуй хүснэгт)

Хорооны нэр	Дарга	Гишүүд	Гол үүрэг
БОНЗ-ын хороо	Ө.Эрдэнэчимэг	Ч.Мөнхчимэг, Ө.Эрдэнэчимэг, Гари Биондо	ESG стратеги, засаглал, ёс зүй, сургалт
Нэр дэвшүүлэх хороо	В.Ганзориг	А.Ганхуяг, Гари Биондо, В.Ганзориг	Шаардлагатай ур чадвартай нэр дэвшигчийг сонгох
Цалин урамшууллын хороо	Ө.Эрдэнэчимэг	А.Ганболд, Ө.Эрдэнэчимэг, Гари Биондо	Цалин, урамшуулал, нөхөн олговор, зах зээлийн нөхцөлд нийцүүлэлт
Аудитын хороо	В.Ганзориг	Г.Бат-Эрдэнэ, В.Ганзориг, Гари Биондо	Дотоод хяналт, ёс зүй, санхүүгийн найдвартай байдал

ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТОЙМ

Хуралдаан

4

Ирц

100%

ШИЙДВЭР, ТОГТООЛ

40

ШИНЭ БҮТЦҮҮД, БАРИМТ  
БИЧГҮҮД:

- 👤 Ёс зүйн хороо шинээр байгуулагдсан
- 📅 Нийгмийн хариуцлагын бодлого
- 📍 Шүгэлүлээх журам
- 🕒 Ёс зүйн хорооны дүрэм
- ✖️ Үйл ажиллагааны журамд нэмэлт төөрчлөлт оруулсан



## 11. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Хэлэлцэн гол асуудлууд:

- 📅 2023 оны санхүүгийн гүйцэтгэл
- ⭐ 2023 оны жилийн тайлан
- ➡ 2024 оны 1-р хагас жилийн тайлан
- ⌚ 2024 оны 2-р хагас жилийн төлөвлөгөө
- 🔥 Тодотгосон төсөв
- 🕒 2025 болон урт хугацааны төлөвлөгөө

### Хэлэлцэж шийдвэрлэсэн бусад чухал асуудлууд:

- 👉 Сонирхлын зөрчилтэй хэлцэлд зөвшөөрөл олгох
- 👉 Ногдол ашиг хуваарилах эсэх
- 👉 Охин компани байгуулах

### 2024 ОНЫ ГОЛ ЗОРИЛТ:

⭐ Засаглал,  
эрсдэл,  
комплайнсын  
нэгдсэн  
тогтолцоо бий  
болгох

👉 Бодлогын  
баримт  
бичгийг уялдаа  
холбоотойгоор  
оловсруулах

👉 Охин  
компаниудын  
түвшинд  
бодлогыг  
дахин  
тодорхойлох



## 11. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТУЗ болон ТУЗ-ийн хороодын хурлын ирц, шийдвэр

ТУЗ-ийн гишүүд	ТУЗ		БОНЗ-ын хороо		Нэр дэвшүүлэх хороо		Цалин урамшууллын хороо		Аудитын хороо		XЭ-дийн хурал
	Хурлын тоо/ирц	Тогтоолын тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц	Зөвлөмжийн тоо	Хурлын тоо/ирц
Гари Биондо (дарга, хараат бус)	4/4	40	4/4	4	2/2	4	2/2	3	4/4	5	1/1
А.Ганхуяг	4/4	40	—	—	2/2	4	—	—	—	—	1/1
А.Ганболд	4/4	40	—	—	—	—	2/2	3	—	—	1/1
Г.Бат-Эрдэнэ	4/4	40	—	—	—	—	—	—	4/4	5	1/1
Ч.Мөнхчимэг (З.Уянга)	1/1	4	—	—	—	—	—	—	—	—	—
	3/3	36	4/4	4	—	—	—	—	—	—	1/1
Г.Чинзориг	4/4	40	—	—	—	—	—	—	—	—	1/1
Б.Бат-Эрдэнэ	4/4	40	—	—	—	—	—	—	—	—	1/1
Ө.Эрдэнэчимэг	4/4	40	4/4	4	—	—	2/2	3	—	—	1/1
В.Ганзориг	4/4	40	—	—	2/2	4	—	—	4/4	5	1/1



## 11.1. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН 2024 ОНЫ ҮҮРЭГ, ГҮЙЦЭТГЭЛ

**Засаглалын зөвлөмж, дэмжлэг:**

- ТУЗ болон түүний хороодод засаглалтай холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгсөн

**Хурлын зохион байгуулалт:**

- Хурлын төлөвлөлт, тэмдэглэл хөтлөлт, тогтоолын төсөл боловсруулалт

**Сургалт ба бүртгэл:**

- ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН
- Хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, үнэт цаасны харилцааг хариуцсан

**Бодлогын баримт бичиг:**

- Бодлогын баримт бичгийг олон улсын стандарт, гэрээ конвенцийн дагуу тодорхойлсон

**Зөрүүний шинжилгээ:**

- Засаглал, эрсдэлийн удирдлага, комплайнсын хэрэгжилтэд үнэлгээ хийж, нэгдсэн тогтолцооны суурийг тавьсан

**Төлөвлөгөө:**

- ТУЗ болон түүний хороодын үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгох санал, зөвлөмж боловсруулах



## 12. Эрх бүхий албан тушаалтан

ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Гүйцэтгэх захирлын орлогч, Санхүү хариуцсан захирал нь Компанийн эрх бүхий албан тушаалтнууд юм. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад 2024 онд олгосон сарын цалин урамшууллын хэмжээг татварын өмнөх үнийн дүнгээр багцлан доорх хүснэгтэд харуулав.

Сарын үндсэн цалингийн хэмжээ (төгрөг)	Эрх бүхий албан тушаалтны тоо
10,000,001 болон түүнээс дээш	3
5,000,001 – 10,000,000	1
0 – ≤5,000,000	6



## 13. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, үнэлгээ

Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03-р сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан Компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, хэрэгжүүлэн ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан 2024 оны 1-р хагас жилийн [Компанийн засаглалын кодексийн үнэлгээний тайлан](#) дурдсанаар Премиум Нэксус ХК нь нээлттэй хувьцаат компаниуд дундаас компанийн засаглалын үнэлгээгээр тэргүүлэгч **ТОП 20** компанийд орж байгаа бөгөөд **Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээгээр 7-р байранд орсон** байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Компани нь **кодексийн гүйцэтгэлийн хэрэгжилт 93.3 хувь** байсан хэмээн дүгнэсэн.

Компани нь 2024 онд засаглал аа сайжруулах зорилгоор өөрийн Засаглал, эрсдэлийн менежмент, комплайнсын тогтолцооны нөхцөл байдлыг хөндлөнгийн байгууллагаар үнэлүүлэн, зөвлөмжийн дагуу холбогдох сайжруулалтын ажлыг хийж эхлээд байна.



## 13. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, үнэлгээ

Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлсэн үнэлгээ

Нэгдсэн үнэлгээний агуулга	Авбал зохих оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	8	66.7%
ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90.0%
Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	5	83.3%
Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100.0%
Эрсдэлийн удирдлага	8	8	100.0%
Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	6	100.0%
Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100.0%
Компанийн соёл	6	6	100.0%
Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100.0%
Нэгдсэн дүн	72	66	93.3%



## 14. Авлига ба ёс зүй

Ёс зүй, сонирхол, авлигатай холбоотой ямар нэг зөрчил, санал, гомдол бүртгэгдээгүй.

ТУЗ нь (i) авлига, хээл хахуулиас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хуулийг сахих, ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагааг дэмжих, Компани болон охин компанийн бүх түвшний ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид болон гуравдагч этгээд гэх мэт оролцогч талуудыг хамарсан **Авлигын эсрэг үйл ажиллагааны журам**; (ii) ажилтнууд, удирдлага болон оролцогч талуудын зайлшгүй мөрдөх ёстой ёс зүйн стандарт, түүнд нийцсэн үйл ажиллагааг дэмжих, хариуцлагатай бизнесийн соёлыг бүрдүүлэх, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, үүрэг хариуцлагыг тодорхойлсон **Ёс зүйн дүрэм**; (iii) ашиг сонирхлын зөрчлийг таних, илрүүлэх, зөрчлийг мэдээлэхэд тавих шаардлага, зөрчлийг шийдвэрлэх механизм, зөрчлийг мэдээлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг тодорхойлсон **Сонирхлын зөрчлийг мэдүүлэх, шийдвэрлэх журам**; (iv) Компани болон охин компанийн хэмжээнд хууль бус, ёс зүйгүй, зөрчилтэй үйл ажиллагааг мэдээлэх, мэдээлэл өгсөн талыг хамгаалах, ёс зүйтэй үйлдлийг дэмжих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг зохистой байдлаар шийдвэрлэх, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх үйл ажиллагааг тодорхойлсон **Шүгэл үлээх журмыг 2023-2024** онуудад тус тус батлан, хэрэгжилтийг ханггуулж ажиллаж байгаа ба 2024 онд Компани болон охин компаниудын түвшинд ёс зүй, ашиг сонирхол, авлига, хээл хахуультай холбоотой **зөрчил, санал, гомдол гараагүй** байна.

Анхаарал хандуулсанд  
**Баярлалаа.**